

**ӨВӨР МОНГОЛ ДАХЬ СОЁЛ, УРЛАГИЙН  
ОДООГИЙН БАЙДЛААС****М.Зэнээ**

Нийт Хятад даяар урлаг уран зохиол болон соёлыг “чөлөөтэй” хөгжүүлэх асуудал ихээхэн яригдаж байгаатай холбогдон Өвөр Монголд ч энэ асуудлыг нэлээд анхаардаг боллоо. Соёл урлагийн талаар тодорхой практик арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаа нь ч тодорхой байна. Өвөр Монголын зохиолчид уран бүтээлчдийн зохиол, бүтээл “соёлын хувьсгал” үндсээрээ буруу байсан учир соёл урлагийн хөгжилд ноцтой саад бэрхшээл учруулсан гэсэн санаа их тусгагдах боллоо. “Соёлын хувьсгалын” үед хэлмэгдсэн олон зуун сэхээтэн, уран бүтээлчдийг сүүлийн жилүүдэд цагаатгажээ. Соёл урлагийн ажилтнууд олон тоогоор хэлмэгдсэн явдал бол Линь Бяо, “дөрвийн бүлгийн” үйл ажиллагаанаас болсон гэж хэвлэлд тайлбарласаар байна. “Дөрвийн бүлгийг” бут цохисноор хятад биш үндэстний соёл “цэцэглэн хөгжих” замд орж байгаа тухай сэдэв хэвлэл утга зохиолд ихээхэн тусгагдаж байна.

1973 онд монгол хэл бичгийг хөгжүүлэх 8 жилийн төлөвлөгөө (1978-1985) гэдгийг баталж, монгол хэл сурах, монгол хэлээр хичээл заах, монгол үндэстний сургууль байгуулах, монгол бичгийн судалгаа явуулах зэрэг ажлыг нэлээд дэмжиж эхэлсэн юм.

1981 III сарын 6-ны “Жэньминь жибао” сонинд цөөн тоот үндэстний сурган хүмүүжүүлэх ажил хятад үндэстэнтэй харьцуулбал хол хоцорч байна. Тэнд одоо болтол олон тооны залуучууд, багачууд бичиг үсэг мэдэхгүй байна. Энэ байдлыг өөрчлөх хэрэгтэй.

Хоцрогдож байгаагийн гол шалтгаан бол үндэстний багшлах боловсон хүчин хүрэлцээгүйтэй холбоотой<sup>1</sup> гэж тэмдэглэжээ. Үүнээс үзвэл Хятад биш үндэстний районуудад сургалтын ажил бүх нийтийг хамарч чадахгүй хөрөнгө мөнгө, байр орон сууц, багшлах боловсон хүчин дутагдах зэрэг бэрхшээл байсаар байгаа ажээ.

Өвөр Монголын өөртөө засах орны хүн ам олон 20 сая орчим болоод байгаагаас 90 орчим хувь нь хятадууд байна. Иймээс монголчууд монгол хэлээр хичээл сургалтын ажлаа явуулдаг цэвэр монгол сургууль байгуулах хүсэлт их гаргадаг боллоо. 1980 оны нэг мэдээнд “Чөлөөлөгдсөний дараа Шилийн хотод нэг монгол сургууль байгуулсан. Гэтэл одоо болтол тэр сургуулийг өргөтгөсөнгүй. Шинээр монгол сургууль нэмж ч байгуулсангүй. Ганц монгол бага сургууль одоогийн

<sup>1</sup> “Жэньминь жибао” 1981-III-6.

шаардлагыг яагаад ч хангаж чадахгүй байгаа учир монгол хүүхэд бичиг үсэг сурах явдал маш бага байна<sup>2</sup> гэжээ.Зарим сургуулийн нийт хүүхдийн тоо 10 гаруйхан байгаа тухай мэдээ ч үзэгдэж байна. Энэ бол хүүхдийг сургуульд хамрах хүрээ бага, багш хүрэлцээгүй, байр байхгүй зэрэг өмнө өгүүлсэн тодорхой шалтгаануудтай холбоотой юм. “Сургалтын программ орчин үеийн шаардлагаас тасархай, багш нарын онолын болоод ерөнхий эрдмийн мэдлэг сул, мэргэжлийн төвшин доогуур байгаагаас сурагчдын мэдлэг муу байна”<sup>3</sup> гэж хэвлэлд тэмдэглэж байгаа нь дээр өгүүлснийг гэрчилж байна.

1983 оны 4-р сарын 20-нд хуралдсан Өвөр Монголын ардын Төлөөлөгчдийн Хурлын чуулган дээр ӨМӨЗО-ы засгийн ордны дарга Бөхөө “сурган хүмүүжил, шинжлэх ухаан бол манай орны (Өвөр Монгол-М.З) сул дорой тал болох тул онцгой анхаарч ажиллах хэрэгтэй”<sup>4</sup> гэж хэлсэн нь ардын боловсролын асуудал нэлээд төвөгтэй хэвээр байгааг харуулж байгаа баримт юм.

“Хятадын бүх үндэстний шинжлэх ухаан, соёл, боловсролын хэмжээг туйлын ихээр дээшлүүлэх хэрэгтэй”<sup>5</sup> гэсэн заавар төвийн хэвлэлд улам их үзэгдэж байна. Гэтэл орон нутагт “нэлээд олон хүн чөлөөтэй сэтгэж болохгүй, санал бодлоо зоригтой хэлэхгүй, хийх бүтээх ажилдаа тууштай хандахгүй”<sup>6</sup> байгаа тухай тэмдэглэсээр байна. Энэ нь сүүлийн жилүүдэд Хятад даяар явагдаж буй “оюун санааны бохирдлоос чөлөөлөх гурван жил” гэдэг улс төрийн кампанитай холбоотой юм. Учир нь 1957 онд явуулсан “цэцэг бүхий дэлгэрч, эрдэмтэн бүхэн уралдаг” гэдэг уриа тухайн үед олон тооны монгол сэхээтнүүдийг хэлмэгдүүлсний нэг адил “оюун санааны бохирдлоос чөлөөлөх” гэгч уриа бас олон тооны хүмүүсийг буруутган хэлмэгдүүлэх үндэс болж мэдэх юм хэмээн хүмүүс болгоомжилж байна. 1985 оны эхээр хуралдаж дууссан хятадын зохиолчдын хорооны 4-р их хурлаас “цэцэг бүхий дэлгэрч, эрдэмтэн бүхэн уралдаг” гэдэг уриаг дахин албан ёсоор давтан гаргасанд ч бас болгоомжлох хандлага байна. 1982 оны 3-р сарын 6-нд ӨМӨЗО-ы засгийн ордны дарга байсан Кун Фей Хөх хотод болсон хөдөлмөрийн сайчуудын хурал дээр үг хэлэхдээ: “Одоо манайд хачин жигтэй нэг үзэгдэл гарах боллоо. Энэ нь олон тооны идэвхтэн хүмүүс сайшаал, шагнал авах дургүй, тэргүүний гэдэг нэр хүлээх дургүй байна. Үүний учир нь муу хэрэг, муу үйлийг эсэргүүцсэн хүн хэрэгт ордогтой холбоотой юм. Зарим сайн хүмүүс дарагдаж, атаа жөтөөнд өртөж, муу хэлэгдэх явдал газар авч буй нь буруу үзэл суртал ихсэж байгааг харуулж байгаа бөгөөд үүнд бүх удирдах хүмүүс анхаарлаа хандуулах ёстой”<sup>7</sup> гэсэн нь хятад дахь монголчуудын дотор болгоомжлох хандлага их байгааг гэрчилж байна.

Сүүлийн үед Өвөр Монголд эрдэм шинжилгээ судалгааны ажилд анхаарч, ялангуяа нийгмийн ухааны талаар нэлээд ажил хийгдэх төлөвтэй байгааг хэд хэдэн баримт харуулж байна. 1979 онд Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны Академи байгуулагдсан нь дотроо Монгол хэл бичгийн хүрээлэн, Монголын уран зохиолын хүрээлэн, Монголын түүхийн хүрээлэн, эдийн засгийн хүрээлэн, Философи сэтгэлгээний хүрээлэн зэрэг хэд хэдэн салбартай ажээ. Мөн онд Хөх хотод Монголын түүх судлах бүх Хятадын нийгэмлэгийг байгууллаа.

<sup>2</sup> Өвөр Монголын өдрийн сонин 1980-XII-26.

<sup>3</sup> “Жэньминь жибао” 1981-VIII-12.

<sup>4</sup> Өвөр Монголын өдрийн сонин. 1983-IV-21.

<sup>5</sup> “Хунци” сэтгүүл Бээжин. 1978. №5, 3-р тал.

<sup>6</sup> “Хунци” сэтгүүл Бээжин. 1979. №3, 3-р тал.

<sup>7</sup> “Мэнгу жибао” 1982-III-7.

Энэ нь нийгэмлэгийн гол зорилго нь Монголын түүхийг шинжлэх ухааны үүднээс судлан хөгжүүлэх нэрээр “хятад сурвалж” гэгчид тулгуурлан түүхийг гуйвуулах, Монголын түүх бол үндэстний их гэр бүл Хятадын түүхийн салшгүй хэсэг гэсэн нотолгоо гаргахад чиглэж байна. Уул нийгэмлэгийн анхны хурал<sup>8</sup> 1979 оны VIII сарын 5-12-нд Хөх хотод болсноос хойш жил бүр Хайлаар, Үрэмч, Куньмин зэрэг хотуудад ээлжлэн хуралдаж билээ. Хуралд монгол судлалын талаар тавигдсан олон тооны илтгэлүүдийн ихэнх нь Монголын түүнийг Хятадын түүхийн хавсарга шинжтэй болгон бодит үнэнийг гүтгэн гуйвуулсан зүйлээр багагүй байна. Гэвч зарим судлаачид Монголын түүх бол Монголын ард түмний түүх л байх ёстой гэсэн байр суурь баримталж судалгаа шинжилгээний ажилд хандаж байгаа байдал бас харагдаж байна. Үүнээс үзвэл Өвөр Монголын түүх судлаачид урьдын адил хоёр чиглэл баримталж байгаа нь тодорхой ажээ. Өвөр Монголд үндэстний соёлыг хөгжүүлэх гэсэн хандлага нь их хан үндэстний дээрэнгүй бодлогод хүчтэй өртөгдөж байснаас болж бас орон нутгийн хэт үндсэрхэг явцуу үзэл рүү хальтран орох байдал ажиглагдаж байна. Сүүлийн үед монгол хэлийг хөгжүүлэх асуудал иймэрхүү хандлагаар нэлээд идэвхжих болов.<sup>9</sup> Гэвч одоохондоо түүнийг буруутгаж, хэлмэгдүүлэх явдал гараагүй байна. Харин дэмжих хэлбэрээр зарим ажлууд зохиогдож байна.

Сүүлийн жилүүдэд Өвөр Монголд ном хэвлэх ажил нэлээд хийгдэж байна. “Алтан товч”, “Эртний хаадын угсаатны тууж”, “Монголын нууц товчоо”, “Жангар”, “Монголын уран зохиолын дурсгалт бичгүүд”, “Монголын түүхийн сурвалж бичгийн есөн зүйл”, “Хүннүгийн түүх” зэрэг нэлээд сурвалж, “Монголын уран зохиолын түүх”, “Монгол эрдэмтэн Мянгат”, “XIII-XVII зууны Монголын түүх бичлэг”, “Юньнаний монгол үндэстний товч түүх”, “Хөх хотын сүм хийдийн түүх” зэрэг олон ном хэвлэгдэн гарлаа. Түүхийн холбогдол бүхий дээрх номыг хэвлэн гаргаж байгаагийн цаана монгол угсаатны төв бол Хятад бөгөөд Монголын түүх бол Хятадын түүхийн салшгүй гэсэн гэсэн санаа агуулагдаж байж болох юм. Хуучны ном зохиол хэвлэхийн зэрэгцээ шинэ үеийн уран зохиолын ном, орчуулгын ном, соёлын болоод судалгааны холбогдолтой сэтгүүл хэвлэх ажил ч хийгдсээр байна. 1980 онд Өвөр Монголд 10 төрлийн сонин, сэтгүүл хэвлэгдэж байсан бол одоо 30 орчим сэтгүүл хэвлэгдэж байгаагийн тал нь Монголын хуучин үсгээр хэвлэгдэж байна. “Цэцэгт нуга”, “Алтан түлхүүр”, “Тал нутаг”, “Цолмон”, “Тал нутгийн дуулал”, “Монгол хэл утга зохиол”, “Оюун түлхүүр”, “Цоморлог”, “Өнөр цэцэг” зэрэг олон сэтгүүл түүх, хэл бичгийн холбогдолтой онолын болоод судалгаа шинжилгээ, шүүмж, уран зохиолын төрөл тууж, өгүүлэл, шүлэг, яруу найргийн зүйл хэвлэгдэх боллоо.

Монгол хэлийг үр хүүхдэдээ заалгах гэсэн олон түмний хүсэл зоригийг харгалзан дээд сургуулийн зарим сурах бичгийг монгол хэлээр орчуулан хэвлэх ажил идэвхжсэн нь хэвлэлийн мэдээнээс ажиглагдаж байна.<sup>10</sup>

Сүүлийн үед Өвөр Монгол Монголд богино хэмжээний үргэлжилсэн үгийн зохиолыг сэтгүүлүүдэд нэлээд хэвлэх болов. Ийм зохиолд “соёлын хувьсгалыг” шүүмжилсэн санааг залуучуудын хайр дурлалтай холбон тавих явдал

<sup>8</sup> Schwarz Henryg. Mongolian Studies in China, “Zenfraalasiatische studien” 1980. p.211;

<sup>9</sup> “Дорно дахины судлалын асуудал” сэтгүүл. 1984, № 2.

<sup>10</sup> Информационный бюллетень агентства Синьхуа. 1981-IV-09

нэлээд харагдах боллоо. Ийм сэдвээр М.Асар, Сайнбаяр, Буяндалай, Одсэр, Сүрэнбат нарын олон залуу зохиолчид бичиж байна.

Зохиол бүтээл туурвихдаа “ухамсраа чөлөөлж” чөлөөтэй бичиж нийтлэхийг уриалж байгаа боловч “оюун санааны бохирдлоос чөлөөлөх” гэгч улс төрийн кампани яаж байгаа нь зохиолчид, уран бүтээлчдийг зөрчилд оруулж байна. 1985 оны 3 дугаар сард Өвөр Монголын намын хорооны дарга Чжоу Хуй энэ оны эхэнд дууссан Хятад зохиолчдын 4-р их хуралд оролцсон Өвөр Монголын хэсэг зохиолчдыг хүлээн авч уулзаад хэлсэн үгэндээ хятад ба цөөнх үндэстний ард түмэн бие биенээсээ салбал уснаас салсан загас адил болно”<sup>11</sup> гэдгийг зохиолчид уран зохиолоор дамжуулан үзүүлэх нь чухал гэжээ. Чжоу Хуй цааш нь “зохиолчид өөр өөрийн үзэл бодол, байр суурьтай байх хэрэгтэй. Өнгөрсөн үед үүнийг “нэр төр хөөцөлдөгч гэж үзээд хавчин хяхаж, идэвх зориггүй болгож байсан”<sup>12</sup> гэж тэмдэглэсэн нь нэг талаар хүн бүр бодол саналаа чөлөөтэй хэлэх тухай 1957 оны хуурамч уриаг санагдуулж байгаагийн зэрэгцээ нөгөө талаар урьд өмнө хэлмэгдсэн хүмүүсийг одоогийн улс төрийн бодлогодоо татан оролцуулах гэсэн зорилготой ажээ.

“ХКН-ын Төв Хорооны 1978 оны 3 дугаар бүгд хурлаас хойш залуу, дунд насны зохиолч, яруу найрагч олон төрлөө”<sup>13</sup> гэж Өвөр Монголын зохиолч Малчинхүү сэтгүүлийн сурвалжлагчид хариулсан нь соёлын хувьсгалын шарх сорви эдгэж, соёл урлаг мухардлаас гарч байна гэсэн санаа болжээ. Үнэндээ мухардлаас гарч байгаа мэт тал харагдаж байгаа боловч хэт баруун тийш гулсан орж урлаг, утга зохиолын гол зарчим болох социалист реализмаас хөндийрөх хандлага улам ихсэж байгаа байдал илт байна.

Сүүлийн жилүүдэд Өвөр Монголд Урлаг, соёлын олон ажилтныг цагаатгалаа. 1978 онд дуучин Буяндэлгэр, хуурч ерөөлч Муу-Охин нарыг цагаатгаж “Жэньминь жибао” сонинд “Линь Бяо, дөрвийн бүлгийн хорлолоос болж... дарга Мао Цзедун, нам хоёроо магтан дуулж чадахгүй”<sup>14</sup> олон жил зовсон юм гэжээ. 1980 онд Бээжин хотод хятад биш үндэстний дуу бүжгийн урлагийн үзлэг болж Өвөр Монголын “улаан мөчир” урлагийн бригадаас 20 хүн, үндэстний дуу бүжгийн чуулгаас 70 хүн оролцжээ. “Улаан мөчир” анх 1957 онд Сөнөд баруун хошуунд бий болсноос хойш иймэрхүү байгууллагын тоо одоо 80 гаруй болоод байна.<sup>15</sup> Өвөр Монголын хүүхэлдэйн жүжигчдийн тоглолт, зураачдын бүтээлийн үзэсгэлэн зэргийг 1980-1982 онуудад Бээжинд нэг биш удаа зохион байгуулсан нь Монгол үндэстний соёл урлагийн ажилтнуудын урам зоригийг дээшлүүлсэн арга хэмжээ болов.

Өвөр Монголд гарч байгаа ном, хэвлэл, жүжиг, кино зэргээс үзэхэд монгол угсаатны түүхийг гуйвуулах, үндсэрхэг үзэл дэвэргэх зэрэг хандлага нэлээд ажиглагдаж байна. 1979 онд Хятадын урлагийн тайзан дээр зохиолч Цао Юй-гийн зохиосон “Ван Чжао цзюнь” гэдэг жүжиг тавигдлаа. Жүжгийн гол агуулга нь МЭӨ I зууны үеийн Хятадын Хан улсын хааны ордны үзэсгэлэнт хүүхэн Ван Чжаоцзюнь

<sup>11</sup> “Нэймэнгу жибао” 1985.III.13.

<sup>12</sup> “Нэймэнгу жибао” 1995.III.13.

<sup>13</sup> “Вэнь Ибао” сэтгүүл. 1984. № 11.

<sup>14</sup> “Жэньминь жибао” 1978. 1. 28.

<sup>15</sup> “Бан Юйтан” сэтгүүл. 1985, № 5, 43-р тал.

Хүннүгийн хаан Хуханье Шаньюйгийн гэргий болсон нь “Хятадын олон үндэстний” эв нэгдлийг бэхжүүлэхэд гарамгай түүхэн үүрэг гүйцэтгэсэн мэтээр харуулжээ. Энэ бол Монгол нь эртнээс Хятадын олон үндэстний нэг гэдэг санааг нотлох гэсэн оролдлогыг хятад олон жилийн турш хийж буйн нэг илрэл билээ. Сүүлийн үед “Орчин үеийн Ван Чжаоцюныг олноор төрүүлэх”<sup>16</sup> тухай асуудал их яригдах болов. Хятадын хэвлэлийн мэдээнээс үзвэл “орчин үеийн үлгэр жишээ Ван Чжацзюнь” гэгдэж буй нэг эмэгтэй бол Хятадын Төрийн Зөвлөлийн ерөнхий сайд асан Чжоу Эньлайн ач охин Чжоу Биньцзянь ажээ. Тэр 1968 онд 15 настайдаа Өвөр Монголд ирж, удалгүй Өвөр Монголын их сургуулийн монгол хэл, уран зохиолын ангид орж суралцан төгсөөд, одоо монгол үндэстний дуучин Лхаасүрэн гэдэг залуутай гэрлэж Өвөр Монголын Нийгмийн Шинжлэх Ухааны академийн монгол уран зохиол судлах хүрээлэнд тасгийн эрхлэгч хийж байна. Ийнхүү хятад монгол хүмүүс хоорондоо гэр бүл болохыг байнга уриалан дэмжиж буй нь эрт цагийн Ван Чжоцзюнь хүүхний үлгэр жишээгээр монголчуудыг өөртөө татах Хятадын үндэстний бодлогын өнөөгийн голч чиглэлийн нэг болж байна.

Монголыг Хятадын хэсэг байсан мэтээр түүхийг гуйвуулах, хуурамч нотолгоо гаргах, түүнийгээ сурталчлах зорилгоор олон ага хэрэглэж буйн нэг нь итали улстай хамтран хийсэн “Марко Поло” гэгч телевизийн 9 ангит кино юм. Уул кино нь Хубилай хааныг Хятадын хаан мэтээр үзүүлэх, олон үндэстний Хятадын нэгтгэхэд тэр гарамгай гавьяа байгуулсан мэтээр харуулахад чиглэжээ.

Чингис хааныг Хятадын хаан байсан мэтээр түүхийг гуйвуулах явдал бас даамжирч байна. Чингисийн төрсний ой, нас барсны ой, төрийн эрхэнд гарсны ой зэргийг жил бүр тэмдэглэж, түүхэнд түүний гүйцэтгэсэн харгис ролийг магтан дэвэргэх зэргээр бодит дүгнэлт өгөхөөс ямагт зайлсхийж ирлээ. Өвөр Монголын кино үйлдвэр, Бээжингийн залуучуудын кино үйлдвэр зэрэг газар хамтран одоо “Чингис хаан” гэдэг өргөн дэлгэцийн кино хийхээр зураг авалтаа эхэлсэн мэдээ байна. Урлаг соёлд анхаарч, түүнийг хөгжүүлэх талаар санаа тавьж байгаа мэт ийм байдлын цаана Монголын түүхийг гуйвуулах, үндсэрхэг үзлийг хөөргөн дэвэргэх, дэлхийн монгол судлалын гал голомт, гол төв бол Хятад мэтээр үзүүлэхийг оролдох зэрэг санаа нуугдаж байна. Мөн үүний хажуугаар Монголын ард түмний түүх, урлаг, соёл уламжлалт зан заншлаа хайрлан хамгаалж, уламжлан хөгжүүлэх гэсэн хандлага нь үндсэрхэг үзэлтэй холилдон явагдаж байгаа байдал ч харагдаж байна.

1982 оны VII сард Өвөр Монголын биеийн тамирын V спартакиад Хөх хотод болсон ба мөн оны IX сард Хятадын бүх “цөөн тоот үндэстний” спартакиад Хөх хотод болж өнгөрөв. Спартакиадад Хятадын 29 муж хот, өөртөө засах орноос ирсэн 1200 гаруй тамирчид, дасгалжуулагчид оролцсон нь Өвөр Монголын хувьд хамгийн том арга хэмжээ болжээ.

Өвөр Монголоос бөхчүүд олон улсын тэмцээнд амжилттай оролцож буй нь монгол үндэстний уламжлалт наадамтай холбоотой юм. Хятадын хэмжээнд зохиогдож буй бөхийн тэмцээнд Өвөр Монголоос оролцсон тамирчид голдуу багаараа 1 байр эзэлж, 5-7 жинд аварга хамгаалж барилдаж байна.

<sup>16</sup> Спецфонд ИВ АН МНР. 1980.

1982 онд Энэтхэг Улсын Дели хотод болсон Ази тивийн спортын 9-р наадамд Өвөр Монгол тамирчид 4 алт, 1 хүрэл медаль хүртжээ. Ер нь Өвөр Монгол бөхчүүдийг Хятадын биеийн тамирын хороо нэлээд анхаарах болов.

Одоо хятад орон даяар хэрэгжүүлж байгаа эдийн засгийн бодлоготой холбогдон соёлын асуудалд ч өөрчлөлт ажиглагдаж байна. “Нээлттэй хаалганы бодлого” гэгчийг дагалдан муж, хот, өөртөө засах орон, үйлдвэр, албан газар, аж ахуйн нэгжүүд гадаад орнуудтай бие даасан худалдаа хийх явдал их боллоо. Үүнийг дагалдан барууны урлаг соёлын нөлөө, элдэв харгис урсгал чөлөөтэй нэвтрэх боломжтой болж байна. Хөрөнгөтний “шалиг завхай зурагтай хэвлэл, зурагт сэтгүүл, түүнийг сурталчилсан кино” хятадад их хэмжээгээр нэвтэрч, энд тэндгүй нууцаар үзүүлэн мөнгөн олон явдал ихсэж буйг зогсоох хэрэгтэй гэсэн суртал ухуулгын ажил сүүлийн үед ихсэж байна.

Энэ бүхнээс үзэхэд Хятад түүний дотор Хятад биш үндэстний урлаг утга зохиол, соёлын асуудалд барууны соёлын нөлөө нэвтэрч, тэр нь социалист урлагийн ерөнхий зарчим, социалист реализмтай зөрчилдөх явдал үүсч, улмаар Дэн Сяопиний “нэг орон-хоёр систем” гэгч үзлийн дагуу хоёр үзэл суртал, хоёр соёл, хоёр урлагийн урсгал өрсөлдөх явдал нэлээд хугацаанд үргэлжлэх төлөвтэй байна.

## ИЗ СОВРЕМЕННОГО ПОЛОЖЕНИЯ КУЛЬТУРЫ И ИСКУССТВА ВНУТРЕННЕЙ МОНГОЛИИ

### Резюме

В статье автор отмечает, что в последнее время в АРВМ частовстает вопрос о необходимости свободного развития культуры и искусства. В связи с этим принимаютс незоторые конкретные меры.

Автор на фактических материалах вскрывает современное положение культуры монгольского населения Внутренией Монголии в различных сферах: образования, литературы, киноискусства, спектаклей спорта и других. В Китае появляются немало произведений, критикующих “культурную революцию”.

Автор подчеркивает, что в последнее время по всему Китаю пропагандируются идеи о создании типичного образа настоящего китайца в социалистическом строительстве, об экономическом преобразовании под призывом “раскрепощения сознания”, выдвинутым 4-ым съездом союза китайских висателей.

В последние годы выпущено немало книг, рассказывающих об истории, литературы неханьских народов. Почти половина из около 30 журналов, выпускаемых в Внутренией Монголии, такие как “Золотой ключик”, “Цветочный луг”, “Сборник произведений”, “Букет цветов” выходят на монгольском языке.

Автор считает, что интеллигенция АРВМ, занимающаяся историей, литературой и монголистикой, работает в двух направлениях. Один придерживаются мнения, что история Монголии есть история монгольского народа. Другие считают, что история Монголии являеца частью истории Китая.

Кроме того, в последнее время замечается тенденция к свободному проникновению влияния западной культуры в культуру и искусство Внутренней Монголии. Широко распространяются также различные парнографические журналы и фильмы. Все это не может не оказывать отрицательное влияние на сознание определенной части людей

Основываясь на некоторых документах, автор делает вывод, что культура и искусство монгольского населения Внутренней Монголии становятся полем соперничества между двумя направлениями: социалистическим реализмом и национализмом на довольно продолжительное время.